

# “АРБИТРЫН ШИЙДВЭРИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

## “MATTERS TO CONSIDER IN IMPROVING THE EXECUTION OF ARBITRATION DECISIONS”

**С.Бямба-Эрдэнэ**

Дотоод хэргийн их сургуулийн багш, Их засаг олон улсын их сургуулийн доктрант, ахмад

**Товч утга:** Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг талууд заавал биелүүлэх бөгөөд харьяалах буюу хариуцагчийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэгч арбитрын шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг гаргаж, шүүхээс арбитрын шийдвэрийг баталгаажуулна. Шүүхээс албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичиж, нэхэмжлэгчид олгодог.

Арбитрын шийдвэрийг шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар өгүүлнэ.

**Түлхүүр үг:** Арбитр, төлбөр төлөгч, төлбөр авагч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Нэгэн судалгаа сонирхуулахад 2022 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд 42181 гүйцэтгэх баримт бичгийн 2.8 их наяд төгрөгийг биелүүлэхээс 19076 гүйцэтгэх баримт бичгийн 595.8 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж, улсын дундаж биелэлт 45.2 хувьтай <sup>1</sup> байснаас арбитрын хэргийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичиг 10 хүрэхгүй хувийг эзэлж байсан.

Арбитр нь үндсэн 4 төрлийн ажиллагаа явуулдаг үүнд:

1. Арбитрын хэлэлцээр байгуулах үед уг хэлэлцээрийн талууд өөр өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

2. Арбитрын хэлэлцээрт заасан, эсхүл түүнд тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяалал нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3. Арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнхийг гүйцэтгэх газар, эсхүл маргааны зүйлтэй илүү холбоотой газар нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

---

<sup>1</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 03/2722 дугаар албан бичгээр өгсөн мэдэгдэл;

4. Арбитрын хэлэлцээрээс үүсэх харилцаа нэгээс олон улсад хамаарна гэдгийг талууд тодорхой тохиролцсон тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа зэргийг ордог.

Арбитрын тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар 43.1-т “...Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрсэн бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг дуусгавар болгох ба талууд ийнхүү хүсэлт гаргасныг арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаж баталгаажуулна...” гэж,

Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т зааснаар “...Талууд эвлэрсэн тухай арбитрын үндсэн шийдвэр энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба арбитрын үндсэн шийдвэр мөн болохыг уг шийдвэрт тусгайлан заана. Уг шийдвэр нь арбитрын үндсэн шийдвэрийн адил хүчин төгөлдөр хэрэгжинэ...” гэж заажээ.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм-ийн 25 дугаар зүйлийн 25.3. “...Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шийдвэр нь арбитрын бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэсэн тухай шийдвэрийн адил хүчинтэй...гэж заасан.

Мөн дүрмийн 25 дугаар зүйлийн 25.4 “...Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэн хэлэлцэх хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид хандах боломжийг талуудад олгоно...” гэж зааж өгсөнөөс харахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн эвлэрүүлэн жуучлах ажиллагаатай төстэй байдаг. Тухайлбал, Арбитр талуудын хүсэлтээр эвлэрлийн журмаар хэрэг хянан шийдвэрлэж, талуудын эвлэрлийг баталж шийдвэр гаргадаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183, 184 дүгээр зүйлийн 184.3 дүгээр зүйлд зааснаар хариуцагч төлбөрөө сайн дураар төлөөгүй тохиолдолд шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг бичиж олгодог.

Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандахдаа эвлэрлийг баталсан шийдвэр, албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг эх хувиар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын гэрээг байгуулж, хүсэлт гарган өгсөнийг цахим бүртгэлд оруулсанаар албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл бүрддэг.

Хариуцсан нэгжийн ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн хүлээн авсан гүйцэтгэх хуудас, захирамжинд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах талаар үүсгэх тогтоолыг ажлын 3 хоногийн дотор гаргаж, хариуцсан тойргийн шийдвэр

гүйцэтгэгчид гүйцэтгэх баримт бичгийг хуваарилж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлдэг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдэд сайн дураар төлбөр төлөх боломжит хугацааг олгох бөгөөд арбитрын хэрэг дээр нэгэн адил төлбөр төлөх боломжит хугацаа олгож сайн дураар төлбөрийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар албад гүйцэтгэх ажиллагааг явуулдаг.

Би Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2022 онд ажиллаж байх хугацаандаа арбитрын шийдвэртэй нийт 940.428 мян.төгрөгийн үнийн дүнтэй 4 гүйцэтгэх баримт бичгийн 737.803 мян.төгрөгийн 2 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгосон.

Ажиллагаанд байгаа үлдэгдэл 202.625 мян.төгрөгийн 2 гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгч арбитрын шийдвэр гарсаны дараа хөрөнгө бусдад шилжсэн байдаг. Анхан шатны шүүхээс албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичүүлж Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандсан байгаа нь төлбөр гаргуулахад хүндрэлтэй нөхцлийг үүсгэсэн.

Арбитрын шийдвэртэй гүйцэтгэх хуудсанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үед эвлэрлийг баталсан шийдвэрт заасан барьцаа хөрөнгийг дурьдаагүй тохиолдол цөөнгүй байдаг.

Сайн дураар төлбөр төлөх хугацааг тодорхой бичсэн шийдвэрт барьцаа хөрөнгийн мэдээлэл нь албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсанд бичигдээгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үед зөвхөн барьцаа хөрөнгө гэж үзэхгүйгээр төлбөр төлөх боломжит бүх аргаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг. Тухайлбал,

Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн банк дахь дансыг битүүмжлэх, хасалт хийх, шинээр данс нээх, хаах, эзэмших эрхийг хориглох тухай тогтоолыг банкуудад хүргүүлэх, үнэт цаас, тээврийн хэрэгсэл, тусгай зөвшөөрлийн эрх, эзэмшил, өмчлөлийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, үзлэг нэгжлэгээр илэрсэн хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж, хураах, шаардах эрх, цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийх, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн хувьд ногдох хувьцааны хэмжээгээр улсын бүртгэлд өөрчлөлт оруулах эрхийг түдгэлзүүлэх зэрэг тодорхой ажиллагааг явуулдаг.

2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн үнэлгээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан талуудаас болон гуравдагч этгээд буюу хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчээс шүүхэд гаргаж байгаа гомдлын тоо их байдаг. Үүнээс шалтгаалан шүүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг болон хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох нь цөөнгүй байдаг. Шүүх, арбитраас шийдвэр гүйцэтгэх

ажиллагааг хянаж гомдлыг хянах хүртэл хүртэл гурван шатны шүүх хурлаар дамжин явсаар арбитрын шийдвэр, захирамж биелэгдэхгүй уддаг.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт талуудаас хөрөнгийн үнэлгээнд холбогдуулан гаргасан шүүхэд хянагдсан нэхэмжлэлийн тоо 2020 онд 111 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 21, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 85, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 5 тохиолдол байна.

Харин 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 216 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 26, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 181, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 9 тохиолдол байна<sup>1</sup>. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, захирамжинд албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад талуудаас хөрөнгийн үнэлгээ болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гаргасан гомдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.5-д заасны дагуу гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд гаргадаг.

Гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн шүүгч нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэхээсээ өмнө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг буюу гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах тогтолцоо байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх үндэслэлгүй гомдол гаргаж арбитрын шийдвэр биелэгдэхгүй байх нэг нөхцөл болдог.

3. Арбитраас эвлэрлийг баталсан шийдвэрийг биелүүлэхэд төлбөрийн шаардлага нь өндөр үнийн дүнтэй буюу 50 сая ба түүнээс дээш үнийн дүнтэй байх нь түгээмэл байдаг.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд 2014 оны 12 дугаар сард нэмэлт орж мөн хуулийн 133 дугаар зүйлийн 133.4.4-т зааснаар төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлсэн байдаг.

Харин 2017 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд 2020 оны 01 дүгээр сард нэмэлт орж мөн хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар 50 сая төгрөгнөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэлээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхээр

---

<sup>1</sup> Б.Даваасүрэн."Шинжээчийн хөрөнгийн үнэлгээ тогтоох үйл явц, эрх зүйн зохицуулалтын шинэчлэл", Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт хурлын илтгэлийн эмхэтгэл.,УБ.,2021 он., 42 дахь тал;

хуульчилсан. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлсэнээр төлбөр төлөгч төлбөрөө төлөх хөшүүрэг болсон. Тухайлбал,

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2020 онд 2732 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2162 иргэн, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснээс шүүхийн шийдвэрт заасан төлбөрөө бүрэн төлсөн 52 гүйцэтгэх баримт бичгийн 61 төлбөр төлөгч иргэн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг сэргээснээс 7 гүйцэтгэх баримт бичиг арбитрын шийдвэртэй, 9 төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч байсан<sup>1</sup>.

Мөн НШШГГ-ын 2021 оны 5 дугаар сарын байдлаар 510 этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэнээс 94 этгээд төлбөрөө төлж эрхээ сэргээлгэж, төлбөрөө төлөөгүй 3 иргэн шүүхэд гомдол гаргаж гадаадад зорчих эрхээ сэргээлгэх шийдвэр гаргуулж 2 нь гадаадад гарч, одоог хүртэл хугацаанд Монгол Улсын хилээр нэвтрээгүй байна<sup>2</sup>.

Мөн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад төлбөр төлөгч, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг төлбөрийн шаардлагыг биелүүлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлдэг боловч төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчээс шүүхэд гомдол гаргах тохиолдол гардаг. Арбитрын эвлэрийг баталсан шийдвэрт заасан хугацаандаа төлбөрөө хуваагаад төлөхгүй байгаа нь төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэл гэж үзэхээр байхад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдэлгүй хилийн хориг тавьсан гэж үзээд гадаадад зорчих эрхийг сэргээх шийдвэр гаргах, үүнээс болоод Монгол улсын хилээр гарснаас болоод шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч улмаар төлбөр төлөгч, иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийг Монгол улсын хилээр нэвтрэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоож түдгэлзүүлэхэд хүрдэг нь харамсалтай.

4. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах үүднээс шүүгч, арбитрч нь хуульд заасны дагуу хөрөнгө хамгаалах, тодорхой үйлдэл хийхгүй байхыг даалгах, нотлох баримт хамгаалах буюу гаргуулах зэрэг тодорхой ажиллагаа явуулахыг даалгасан шийдвэр гарган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж болно.

Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “...Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл уг ажиллагааны явцад арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах энэ хуулийн 19.2-т заасан арга хэмжээ авахуулахаар

---

<sup>1</sup> Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын судалгаа;

<sup>2</sup> Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2021 оны 5 дугаар сарын судалгаа;

шүүхэд хүсэлт гаргасан, шүүх уг хүсэлтийг хангасан шийдвэр гаргасан нь арбитрын хэлэлцээрийг зөрчсөнд тооцогдохгүй...” гэж заажээ.

Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч шийдвэрийг эх хувиар нь баталгаат шуудангаар эсхүл бичиг хүргэгчээр хүргүүлэхэд хугацаа алддаг тул цахим хэлбэрт шилжүүлж, нэн даруй ирүүлж, дараа нь эх хувийг нь хүргүүлдэг болох хэрэгцээ шаардлага бий болсон.

Ялангуяа арбитрын шийдвэрийг эх хувиар нь хүлээн авсаны дараа шийдвэр гүйцэтгэгч баталгаажуулах арга хэмжээг авах хооронд хөрөнгө үрэгдэх, устгах, захиран зарцуулах эрх бусдад шилжиж хөрөнгийг хамгаалж чадахгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэл өндөр байдаг. Мөн нотлох баримтыг хамгаалахад хугацаа алдсанаас болж хүндрэл үүсч болно.

## ДҮГНЭЛТ

Арбитр шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг хэлбэр бөгөөд шүүх, арбитр болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын салшгүй уялдаа холбоонд хэрэгжиж байна.

Арбитрын шийдвэрт заасан тодорхой төрлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг гүйцэтгэх хуудас олгох шүүх нь дурьдаж бичдэг болох шаардлага бий.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгоход арбитрын шийдвэрт гүйцэтгэх хуудас олгосон шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, хүлээн авах ёстой гомдол мөн эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг болох хэрэгтэй.

Мөн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар мэдэгдлийг төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид биечлэн гардуулах гэж төлбөр төлөгчийг хайж, олох асуудлыг зогсоож, цахим шуудангаар эсхүл гар утсаар нь мэдэгдэж нэн даруй түдгэлзүүлж болох эрх зүйн орчныг бүрдүүлж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шүүх хүлээн аваад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдлийг биечлэн гардуулаагүй, оргон зайлах үндэслэл бүрдээгүй гэх үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгох явдлыг зогсоож, эвлэрлийг баталсан шийдвэрт заасан хугацаанд төлбөрийг хувааж төлөөгүй явдлыг төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэлд тооцож төлбөр төлөгчийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй юм.

Мөн Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг боловсронгуй болгож шийдвэрийг цахим хэлбэрээр шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллагад хүргүүлэхээс гадна гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд шийдвэр гарахаас өмнө хэрэгжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал хариуцагч, төлбөр төлөгч нь гадаад улс руу оргон зайлахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх болно.

## **САНАЛ**

1. Арбитрын шийдвэрт заасан тодорхой төрлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсанд тодорхой зааж бичих,

2. Арбитр гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

3. Шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх,

4. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахыг даалгасан шийдвэрийг цахим хэлбэрээр хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,

5. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний нэг төрөл болгон авч үзэх, биечлэн мэдэгдэх шаардлагагүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх